



П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ
УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/139

Улаанбаатар хот

“Даатгуулагчид хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны төв”-ийн бэлтгэл үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.10.1, 17.10.11, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 10 дугаар тогтоол, Эмнэлгийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.2, 4 дүгээр зүйлийн 4.10.1, 4.10.4, 4.10.5, 4.10.8, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.4, 2.7.3, 7 дугаар зүйлийн 7.2-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Даатгуулагчид хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо” бэлтгэл үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. “Даатгуулагчид хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны төв”-ийн бэлтгэл үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэх удирдлагын багаар хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Нандинцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг батлагдсан төсвөөс гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга (М.Энхчимэг)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Оюунчимэг)-д даалгасугай.

ЗАХИРАЛ Ц.ТӨМӨР-ОЧИР



160810100281

П.Н Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв
эмнэлгийн захирлын 2025 оны 07 сарын 04-ны
өдрийн 139 дугаар тушаалын хавсралт



ДААТГУУЛАГЧИД ХОРТ ХАВДРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ, ОНОШИЛГОО” БЭЛТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Нандинцэцэг (Эмнэлзүй эрхэлсэн дэд
захирлын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Г.Бадамцэцэг (Зөвлөх поликлиникийн
тасгийн эрхлэгч)

Ажлын хэсгийн гишүүд:

Г.Улзмаа (Хоол боловсруулах эрхтэн
судлалын тасгийн эрхлэгч)

Д.Жавзан-Орлом (Уушги судлалын
тасгийн эрхлэгч)

Д.Дэлгэрцэцэг (Дүрслэл оношилгооны
лавлагаа төвийн эрхлэгч)

Б.Баттүвшин (Эмнэлзүйн лавлагаа
лабораторийн эрхлэгч)

Д.Тунгаамаа (Сувилахуй эрхэлсэн дэд
захирал)

Т.Оюунчимэг (Эмнэлгийн тусламж
үйлчилгээ, чанар аюулгүй байдлын
албаны даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

Б.Альгирмаа (Захиргаа хүний нөөцийн
албаны дарга)

Г.Энхболд (Мэдээлэл технологийн
албаны дарга)

С.Долгор (Эрүүл мэндийн эдийн засаг
төлөвлөлтийн албаны дарга)

Д.Төрмөнх (Инженер техник аж, ахуйн
албаны дарга)

Г.Цэнгэл (Эмнэлгийн тоног
төхөөрөмжийн албаны дарга)

Т.Отгонбилэг (Эм зүйн албаны дарга)

Б.Золзаяа (Захиргаа хүний нөөцийн
албаны Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн ажилтан)